



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар А-234/А/103

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /бригадын генерал Ц.Амгаланбаяр/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/, Улсын ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс /Э.Амарбат/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2013 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/130, А/131 дүгээр тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН
ЗӨВЛӨХ

С.БЯМБАЦОГТ

М.ЭНХ-АМГАЛАН

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих болон мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн, прокурорын болон тодорхой ажил, үйлчилгээ гүйцэтгэх, үйл ажиллагаа явуулах эрх, зөвшөөрлийг олгосон байгууллага, албан тушаалтан /цаашид “эрх бүхий байгууллага, албан тушаалтан” гэх/ нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд тус тус хяналт тавина.

1.3.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд харьяа шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн үйл ажиллагаанд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангана.

Хоёр. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих

2.1.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтыг ялтан, эрх бүхий ажилтан, албан тушаалтан, иргэнээс тайлбар, тодорхойлолт, баримт бичиг гаргуулан авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг /цаашид “хувийн хэрэг” гэх/ болон түүнд холбогдох баримт бичигтэй танилцах, шалгах, ялтныг биечлэн болон цахимаар шалгах, санал, тогтоол гаргах, ялтантай уулзах, тэмдэглэл үйлдэх, тоо бүртгэл хөтлөх, шаардлагатай байгууллага, албан тушаалтантай хамтран шалгалт хийх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

2.2.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, ахлах шийдвэр гүйцэтгэгч нь хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа хууль, журамд заасны дагуу явагдаж байгаа эсэхэд дараахь байдлаар хяналт тавина:

2.2.1.ахлах шийдвэр гүйцэтгэгч нь ялтны хувийн хэрэгтэй сар бүр танилцаж, хяналт тавина;

2.2.2.эрх бүхий албан тушаалтан нь шаардлагатай тохиолдолд хувийн хэрэгтэй хэдийд ч танилцаж болно;

2.2.3.энэ журмын 2.2.1, 2.2.2-т заасан албан тушаалтан нь удирдах ажилтнаас хувийн хэрэгтэй танилцсан тухай тэмдэглэлийг хөтөлж, шаардлагатай тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгах үүргийг шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгчид бичгээр өгч, биелэлтийг тооцон заавар, зөвлөмжөөр ханган ажиллана;

2.2.4.хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь энэ журмын 3.2-т заасан үндэслэлээр аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс ирүүлсэн хувийн хэрэг, холбогдох материалын үндэслэлтэй эсэхийг хянаж, ажлын 3 хоногийн дотор харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст буцаах, эсхүл шилжүүлэх арга хэмжээг авна;

2.2.5.ахлах шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэгчээс гаргасан санал, хувийн хэрэгтэй танилцаж, саналаа хууль, журамд заасан хугацаанд үндэслэлтэй гаргасан эсэх болон хувийн хэргийн бүрдлийг хянана;

2.2.6.ахлах шийдвэр гүйцэтгэгч нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын улсын хилээр гарах эрхийг хязгаарлах, түр цуцлах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлж байгаа эсэхэд хяналт тавина;

2.2.7.ахлах шийдвэр гүйцэтгэгч улсын хилээр гарах эрхийг хязгаарласан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтнуудын бүртгэлийг прокурортой улирал бүр тулгалт хийнэ.

Гурав. Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

3.1.Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 153.2-т заасан эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолын хувийг прокурорт 5 хоногийн дотор хүргүүлнэ.

3.2.Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээд өөр орон нутагт оршин суух эсхүл торгох ял шийтгүүлсэн хуулийн этгээдийн ажил хэргээ байнга явуулдаг, удирдах байгууллага болон түүний эд хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн харьяаллаар шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр хувийн хэргийг, албан бичгийн хамт Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд хүргүүлж, прокурорт мэдэгдэнэ.

3.3.Шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 158.2-т зааснаар ял эдэлж дууссан тогтоолыг хүчингүй болгосон прокурорын шийдвэрийг үндэслэн тухайн ялтны ялыг үргэлжлүүлэн эдлүүлнэ.

Дөрөв. Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх:

4.1.Шийдвэр гүйцэтгэгч эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоолыг хүлээн авмагц ял шийтгүүлсэн этгээдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 160.1-д заасан хугацаанд торгох ялыг биелүүлэх тухай мэдэгдлийг гардуулна.

4.2.Энэ журмын 4.1-д заасан мэдэгдэлд хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, хаяг, ялтны ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, шүүхийн шийдвэрийн он, сар, өдөр, дугаар, шүүхээс оногдуулсан ялын хэмжээ, торгох ялыг биелүүлэх хугацаа, торгуулийн мөнгийг тушаах байгууллага болон банкны нэр, дансны дугаар, тогтоосон хугацаанд торгуулийг төлөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага зэргийг тодорхой тусгана.

4.3.Шийдвэр гүйцэтгэгч нь ял шийтгүүлсэн этгээдийг торгууль төлсөн талаар тэмдэглэл үйлдэж, холбогдох баримтыг эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэгт хавсаргана.

4.4.Шийдвэр гүйцэтгэгч сар бүр ял шийтгүүлсэн этгээдийг дуудан ирүүлж, шүүхээс оногдуулсан торгуулийг тогтоосон хугацаанд төлж барагдуулах талаар тайлбар авна.

4.5.Шийдвэр гүйцэтгэгч нь ялтан торгох ялыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 160.1-д заасан хугацаанд төлж барагдуулаагүй шалтгаан, нөхцөлийг судалж, саналаа ахлах шийдвэр гүйцэтгэгчид ажлын 3 хоногийн дотор танилцуулна.

4.6.Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэгч болон ялтны саналтай танилцаж, шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 160.2-т заасан хугацаагаар сунгах эсэх талаар ажлын 3 хоногийн дотор тогтоол гарган шийдвэрлэж, прокурор болон ялтанд мэдэгдэнэ.

4.7.Ял шийтгүүлсэн хуулийн этгээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 160.1 дэх хэсэг эсхүл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 160.2-т заасны дагуу сунгасан хугацаа дуусгавар болоход шүүхээс оногдуулсан торгуулийг төлөөгүй бол шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 94.1-д заасан түүний хөрөнгөнөөс албадан гаргуулах ажиллагааг даруй эхлүүлнэ.

Тав. Нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх:

5.1.Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163.1-д заасан жагсаалтаас ялтныг аль байгууллагад нийтэд тустай ажил хийлгэхийг сонгож, тогтоол гаргана. Ялтныг ажиллуулах тухай гэрээний маягт улсын хэмжээнд нэг загвартай байх бөгөөд маягтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

5.2.Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтан нь эрүүл мэндийн байдал, эзэмшсэн мэргэжил, ур чадвар, хөдөлмөр эрхэлж буй эсэх болон холбогдох тодорхойлолт, лавлагааг гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

5.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163.6-д заасан мэдэгдэлд ялтны ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, шүүхийн шийдвэрийн он, сар, өдөр, дугаар, шүүхээс оногдуулсан ялын хэмжээ, албадан ажил хийлгэх ялыг биелүүлэх хугацаа, ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага зэргийг тодорхой тусгана.

5.4.Шийдвэр гүйцэтгэгч дараахь байдлаар нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны ажлыг биечлэн шалгаж, хяналт тавина:

5.4.1.ялтны ажлын байр, цаг ашиглалт, цагийн бүртгэл, ажлын гүйцэтгэлийг газар дээр нь очиж шалгах;

5.4.2.ажлын цагийн бүртгэл, ажлын гүйцэтгэлийг үндэслэн ялын тооцоо хийх;

5.4.3.нийтэд тустай ажил хийлгэж байгаа байгууллага ялтныг ажиллуулж байгаа хөдөлмөрийн нөхцөл болон ялтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч буй эсэх, ажлын тусгай хувцас, хөдөлмөрийн багаж, хэрэгслээр хангаж буй байдал зэрэг холбогдох хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг шалгах.

5.5.Цагдаагийн байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг давсгэрт оршин суух ялтанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163.7, 163.8, энэ журмын 5.4-т заасны дагуу хяналт тавьж, ял эдлэлтийн талаарх тодорхойлолтыг харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст сар бүрийн 5-ны өдрийн дотор хүргүүлнэ.

5.6.Шийдвэр гүйцэтгэгч нь энэ журмын 5.5-д заасан тодорхойлолтыг үндэслэн ялын биелэлтийг тооцно.

5.7.Шийдвэр гүйцэтгэгч нь нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 165.1-д заасан зөрчил гаргасан тохиолдолд түүнд сануулга өгч, прокурорт мэдэгдэнэ.

5.8.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 164.3-т зааснаар нийтийн хөдөлмөрийн дайчилгаанд дайчлагдан ажилласан цагийн тооцоог тухайн ажил олгосон байгууллагаас авах бөгөөд өдөрт 4-өөс дээш цаг ажилласан бол хуульд заасан хугацаагаар дараагийн өдөрт шилжүүлэн тооцно.

Зургаа. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх:

6.1.Шийдвэр гүйцэтгэгч эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоолыг хүлээн авмагц зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд хэрэглэх тоног төхөөрөмжийн болон ял эдлүүлэх нөхцөлийн талаарх саналаа ахлах шийдвэр гүйцэтгэгчид танилцуулна.

6.2.Ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ журмын 6.1-д заасан нөхцөл, тоног төхөөрөмжийг тогтоох бөгөөд энэ тухай тогтоол гаргаж, хувийг прокурорт хүргүүлнэ.

6.3.Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд хөдөлгөөнт болон суурин хяналтын тоног төхөөрөмжийг эвдэж, гэмтээсэн тохиолдолд засвар үйлчилгээ хийх болон түүнтэй холбогдон гарах бусад зардлыг нөхөн төлүүлэх талаар танилцуулна.

6.4.Шийдвэр гүйцэтгэгч тухайн ялтанд холбогдох шүүхийн шийдвэр болон бусад шаардлагатай мэдээллийг техникийн хяналтын ажилтанд гаргаж өгнө.

6.5.Техникийн хяналтын ажилтан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 171.2-т заасныг баримтлан хяналт тавина.

6.6.Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд сард нэгээс доошгүй удаа биечилсэн хяналт тавьж, тэмдэглэл үйлдэн хяналтын хувийн хэрэгт хавсаргана.

6.7.Шийдвэр гүйцэтгэгч биечилсэн хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 172.3-т заасан хугацаанд тавих бөгөөд ажлын бус өдөр, эсхүл шөнийн цагаар явуулах тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, энэ тухай тэмдэглэлд тусгана.

6.8.Шийдвэр гүйцэтгэгч орон нутгийн алслагдмал газарт ял эдэлж буй ялтны талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 172.4-т заасны дагуу авсан мэдээллийг Цагдаагийн байгууллага /албан тушаалтан/-д хандан шалгуулна.

6.9.Цагдаагийн байгууллага /албан тушаалтан/ нь энэ журмын 6.8-д заасан мэдээллийг шалгаж, холбогдох материалыг тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ирүүлнэ.

6.10.Биечилсэн болон цахим хяналтаар илэрсэн зөрчлийг ялтанд танилцуулж, зөрчлийн акт, тэмдэглэл үйлдэнэ.

6.11.Шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 173, 174-т заасан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчлөх болон өөрчлөх талаар гаргасан ялтны хүсэлт, холбогдох баримтыг үндэслэлтэй эсэхийг хянаж, саналаа ахлах шийдвэр гүйцэтгэгчид танилцуулна.

6.12.Шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 176.1-д заасан хохирлыг нөхөн төлүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр /акт/-ийг үндэслэн тухайн гэм буруутай этгээдэд мэдэгдэл хүргүүлнэ.

6.13.Энэ журмын 6.12-т заасан этгээд учруулсан хохирлыг мэдэгдэлд заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

Долоо. Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх:

7.1.Шийдвэр гүйцэтгэгч нь эрх хасах ял шийтгүүлсэн ялтанд эрх зөвшөөрөл олгосныг нотлох баримт бичгийн эх хувийг хураан авч, тэмдэглэл үйлдэн хувийн хэрэгт хавсаргана.

7.2.Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь энэ журмын 7.1-д заасан баримт бичгийг эх хувиар нь төвлөрүүлэн хадгалж, ялын хугацаа дуусмагц шийдвэр гүйцэтгэгчид хүлээлгэн өгч, шийдвэр гүйцэтгэгч нь ялтанд баримт бичгийг буцаан олгоно.

7.3.Эрх хасах ял шийтгүүлсэн ялтан нь энэ журмын 7.1-д заасан баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд энэ тухай баримт, лавлагааг шийдвэр гүйцэтгэгчид гаргаж өгөх үүрэгтэй.

7.4.Эрх, зөвшөөрөл олгосон байгууллага, албан тушаалтан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 179.1-д заасан хугацаанд ялтанд олгосон эрх, зөвшөөрлийг хүчингүй болгож, шийдвэрийн хувийг, албан бичгийн хамт харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ажлын 5 хоногийн дотор хүргүүлж, мэргэжлийн үйл ажиллагаанд хяналт тавина.

7.5.Ялтанд хяналт тавьж байгаа Цагдаагийн байгууллага /аймаг, дүүрэгт Замын цагдаагийн хэлтэс, тасаг, суманд хэсгийн төлөөлөгч/ нь тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ял шийтгүүлсэн ялтны ял эдлэлтийн байдалд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 177.4, 180.3-т заасны дагуу хяналт тавьж, энэ талаар харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст сар бүрийн 5-ны өдрийн дотор бичгээр хүргүүлнэ.

7.7.Шийдвэр гүйцэтгэгч эрх хасах нэмэгдэл ял шийтгүүлсэн хоригдлын шүүхийн шийдвэрийг ял эдэлж буй хорих ангид хүргүүлнэ.

7.8. Эрх хасах ял шийтгүүлсэн ялтан ял эдлэх хугацаанд өөр ажил, албан тушаалд шинээр орох, шилжин томилогдох, тодорхой үйл ажиллагаа эрхлэх бол шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэх үүрэгтэй.

7.9.Эрх хасах ял шийтгүүлсэн этгээд зөрчил гаргасан тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгч Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

Найм. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны талаар тоо бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргах

8.1.Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн талаарх тоо бүртгэлийг аймаг, нийслэлд тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл, цахим санг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлж, хяналт тавина.

8.2.Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн талаарх нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээ, тайлан тэнцлийг нэгтгэх бөгөөд тухайн газар, хэлтсийн дарга хяналт тавина.

8.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн шилжилт хөдөлгөөн, ялын биелэлтийн талаарх мэдээ, судалгааг сар бүр гарган, харьяа прокурорын газар болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд хүргүүлнэ.

8.4.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс ирүүлсэн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн шилжилт хөдөлгөөн, ялын биелэлтийн талаарх мэдээ, судалгааг нэгтгэж, сар бүр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага болон Улсын Ерөнхий прокурорын газарт тус тус хүргүүлнэ.

Ес.Мэдээллийн цахим сан бүрдүүлэх, ашиглах

9.1.Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны талаар дараахь төрлийн мэдээллийн цахим санг бүрдүүлнэ:

9.1.1.хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн цахим бүртгэл, мэдээллийн сан;

9.1.2.зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээдийн цахим хяналтын мэдээллийн сан.

9.2.Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст тойргийн шийдвэр гүйцэтгэгч нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны тоо бүртгэлийг хөтлөхдөө мэдээллийн санд хувийн хэргийг цахим хэлбэрээр бүртгэнэ.

9.3.Шийдвэр гүйцэтгэгч тухайн ялтанд холбогдох шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор цахим хувийн хэрэг нээж, мэдээллийн санд бүртгэнэ.

9.4.Шийдвэр гүйцэтгэгч цахим хувийн хэргийн баяжилт, шилжилт, хөдөлгөөний мэдээллийг тухай бүр тогтмол бүртгэнэ.

9.5.Аймаг, нийслэлийн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн цахим тоо бүртгэл хөтлөлт, мэдээллийн сан бүрдүүлэлтэд тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга, ахлах шийдвэр гүйцэтгэгч хяналт тавих бөгөөд улсын нэгдсэн цахим тоо бүртгэл хөтлөлт, мэдээллийн сан бүрдүүлэлтэд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангана.

9.6.Цахим хяналтын нэгж нь зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын мэдээллийн сан, хөдөлгөөний тэмдэглэл /маршрут/-ийн сан болон зөрчлийн сан үүсгэн, тасралтгүй хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

9.7.Хууль сахиулах байгууллагууд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, судалгаа шинжилгээ хийх зорилгоор хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтны мэдээллийн санг ашиглаж болох бөгөөд мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж хамтран ажиллана.

9.8.Энэ журмын 9.1-д заасан мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр холбогдох байгууллага, албан тушаалтанд гаргаж өгнө.

9.9. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны мэдээллийн сан нөөцлөлт, сүлжээний хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг мэдээлэл технологийн нэгж хариуцан ажиллана.

9.10.Мэдээллийн санд хандах нууц үгийн нууцлал, хамгаалалтыг хандах эрх бүхий алба хаагч өөрөө хариуцна.

9.11.Хорихоос өөр төрлийн ялын бүртгэлийн системд нэвтрэх эрх бүхий алба хаагч ажлаас чөлөөлөгдсөн, шилжин томилогдсон тохиолдолд мэдээлэл технологийн

нэгжид даруй мэдэгдэж, түүний системд нэвтрэх эрхийг хүчингүй болгох ба тухайн ажилд томилогдсон алба хаагчид нэвтрэх нэр, нууц үгийг шинээр олгоно.

9.12. Мэдээллийн санд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны мэдээллийг энэ журамд заасан хугацаанд бүртгээгүй, баяжилт, шилжилт хөдөлгөөнийг хийгээгүй, хяналт тавиагүй нь тогтоогдвол тухайн албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болно.

---oo0oo---